



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 1/243

Арвайхээр сум

**Дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 11 дүгээр цэцэрлэгийн багш нарын Улаанбаатар хотод хөгжлийн онцлогтой сурагчдад боловсрол олгодог сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд зохион байгуулдаг урлагийн наадамд оролцох зардалд 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Тус 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0502